

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН СОНСОГЧИЙН ЁС СУРТАХУУНЫ ХЭМ ХЭМЖЭЭ

THE MORAL STANDARDS OF CADETS AT THE UNIVERSITY OF INTERNAL AFFAIRS

Лувсанравдангийн Энэрэл*

Дотоод хэргийн их сургуулийн Сургалтын бодлого төлөвлөлтийн газрын Суралцагчийн хөгжлийн төвийн соёл, олон нийтийн ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, ахмад

Capt. Enerel Luvsanravdan, Senior Specialist in Social Programs and Culture, Student Development Center, Department of Educational Policy and Planning, University of Internal Affairs

Хүрэлбаатарын Ёндонжамц

Мөн сургуулийн Хангамж, ар талын газрын Авто техникийн албаны инженер-шалгах механик, дэслэгч

Lt. Khurelbaatar Yondonjamts, Engineer-Inspector (Mechanical), Auto Technical Department, Supply And Service Department, University of Internal Affairs

Жамбалдоржийн Даваадорж

Мөн сургуулийн Цэргийн албаны зохион байгуулалт, бэлэн байдлын газрын зэвсэг, хангалт хариуцсан чиглэлийн ахлах офицер, ахмад

Capt. Davaadorj Jambaldorj, Senior Officer in Charge of Weapons And Supplies, Military Service Organization and Preparedness Department, University of Internal Affairs

*хариуцлагатай зохиог:enerelmarujin@gmail.com

Хураангуй: Дотоод хэргийн их сургууль /цаашид “ДХИС” гэх/-ийн сонсогчдын хувьд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан цэргийн тангараг өргөсөн энэ үеэс хоорондын харилцаа, албаны бүхий л үйл ажиллагаа Цэргийн дүрэм, ДХИС-ийн Суралцагчийн ёс зүйн дүрмээр зохицуулагдаж эхэлдэг бөгөөд ёс суртахууны олон үүргийг хүлээдэг ч эдгээрийг сонсогчид тэр бүр анзаарч хардаггүй.

Тиймээс ДХИС-ийн сонсогчдын ёс суртахууны төлөвшлийг нэмэгдүүлэхэд тэдний эх орон, төр, ард түмэндээ өргөсөн Монгол Улсын цэргийн тангараг болон өдөр тутмын хичээл сургалт, албаны үйл ажиллагааг зохицуулж буй цэргийн дүрмүүд, мөн Их сургуулийн суралцагчийн ёс зүйн дүрэм дэх ёс суртахууны үндсэн зарчим, агуулгыг тодорхойлж тайлбарлах нь нэн чухал ач холбогдолтой гэж үзсэн тул дээрх эрх зүйн баримт бичгүүдийг шинжлэх ухааны задлан шинжлэх аргыг ашиглан судалж ёс суртахууны агуулга бүхий гол заалтуудыг Монгол хэлний тайлбар толь, ёс суртахууны үндсэн зарчмуудтай уялдуулан тайлбарлахыг зорилоо.

Энэхүү судалгааны үр дүнд сонсогчдод ёс зүй, ёс суртахууны талаар мэдлэг олгож, хандлага төлөвшүүлэх сургалт, судалгааны материал бүрдэж, сонсогчдын зөрчлийн тоо багасах юм.

Abstract: For students of the University of Internal Affairs, from the moment they take the Military Oath, which was approved by the decree of the President of Mongolia, all relationships and official activities are regulated by the Military Regulations and the Student Code of Conduct of the University of Internal Affairs, and they assume many moral obligations, but students often do not notice these. Mongolian Military Oath they swear to

their country, state, and people, the military regulations that govern their daily education and official activities, and the ethical code of conduct for university students.

Therefore, in order to enhance the moral development of the students of the Mongolian Military Academy, it is considered very important to define and explain the basic principles and content of morality in the Mongolian Military Oath, which they take to their homeland, state, and people, the military regulations that regulate daily training and service activities, and the University Student Code of Ethics. Therefore, we aimed to study the above legal documents using scientific analysis methods and explain the main provisions with moral content in accordance with the Mongolian language glossary and basic moral principles.

The results of this study will provide listeners with knowledge about ethics and morality, create training and research materials to shape attitudes, and reduce the number of listener violations.

Түлхүүр үгс. Цэргийн тангараг, цэргийн дүрэм, ёс зүй, ёс зүйн дүрэм, ёс суртахуун.

Keywords: Oath of enlistment, military regulations, ethics, code of ethics, morality.

Удиртгал

Гаднын улс орнуудад ёс зүй, ёс суртахууны төлөвшилийг улс орны хөгжлийн түлхүүр гэж үзэх болсон бөгөөд ёс суртахуунтай алба хаагчид тухайн байгууллагын үндсэн хүч хэмээн үнэлэгдэх болсон.

Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын үзэл баримтлалын 3.3.3.1. “Нийгмийн ёс суртахуун, сэтгэл зүйн төлөвшил, үнэт зүйлсийн нэгдмэл байдлыг хангах нь үндэсний аюулгүй байдал, эв нэгдэл, зөвшилцлийг хангах суурь болно.; “Алсын хараа-2050” үндэсний хөтөлбөрт “...хүмүүнлэг, оюунлаг, ёс суртахуунтай эх оронч, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай монгол хүнийг бэлтгэх...”, 2023 онд шинээр батлагдсан Монгол Улсын “Боловсролын ерөнхий хууль”-ийн 4.1-т боловсролын зорилгыг “...хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцан ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэх...”, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 180 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Цэргийн нийтлэг дүрэм”-д цэргийн албан хаагчийн эрмэлзэх зүйлсийг “Эх оронч байх”, “Шударга байх”, “Эр

зоригтой байх”, “Ёс зүйтэй байх”, ДХИС-ийн Суралцагчийн ёс зүйн дүрмийн 4.1.1-т “хүнлэг энэрэнгүй байж, шударга ёсыг дээдлэн, хувийн ашиг сонирхлоос ангид байна”, 4.1.5-т “ёс суртахууны үлгэр дуурайлалтай суралцана” гэж тус тус заасан. Энэ нь ёс суртахуун бол сонсогчдын үүрэг, хариуцлага бөгөөд улс орны аюулгүй байдлын үндэс, тэдний сурч боловсрох, чадварлаг мэргэжилтэн болж хөгжихийн гол тулгуур болохыг тодорхойлсон.

ДХИС-ийн сонсогчдын өргөсөн тангараг, өдөр тутамдаа хэрэгжүүлж ажилладаг цэргийн дүрэм, Их сургуулийн Ёс зүйн дүрэм дэх ёс суртахууны хэм хэмжээ шаардсан агуулга, заалтуудыг ухамсарлан хэрэгжүүлэх нь сонсогчдын, эдгээр хэм хэмжээнд тулгуурлан тэдэнд ёс суртахуун төлөвшүүлэх нь багшлах бүрэлдэхүүн бидний үүрэг юм.

Их сургуулийн сонсогчдын хэмжээнд гарсан зөрчлийн төрөл, тоон үзүүлэлтийг 2024 оны байдлаар авч үзэхэд, нийт 763 зөрчил бүртгэгдсэнээс хичээлээс хоцорсон 95.5%(728/763) зөрчил, хувцасны зөрчил 3%(23/763), харилцааны зөрчил 0.2%(2/763), бичиг баримт биедээ авч яваагүй зөрчил 1.3%(10/763) байна.





Зураг 1. Зөрчлийн мэдээ

Дээрх зөрчлийн төрөл, тоон үзүүлэлтээс цэргийн сургуулийн сонсогчид өөрсдийн үүрэг, хариуцлагаа ухамсарлаагүй байдал ажиглагдаж байна.

Тиймээс ДХИС-ийн сонсогчдын ёс суртахууны хэм хэмжээг тодорхойлсон Монгол Улсын цэргийн тангараг, Цэргийн дүрмүүд, ДХИС-ийн Суралцагчийн Ёс зүйн дүрэм дэх ёс суртахууны агуулга бүхий гол заалтуудыг тайлбарлахыг зорилоо.

Үндсэн хэсэг

Нэг. Монгол Улсын цэргийн тангаргийн ёс суртахууны агуулга

Монгол Улсын Цэргийн албаны тухай хууль заасны дагуу Монгол Улсын иргэн ДХИС-д элсээд *"Монгол Улсын иргэн Би Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ үнэнчээр биелүүлж, өвөг дээдсийнхээ ариун гал голомт болсон Монгол Улсынхаа халдашгүй дархан байдлыг амь бие үл хайрлан батлан хамгаалахаа эх орон, төр, ард түмэндээ андгайлан тангараглая.* (Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд, 2022)

Би ард түмнийхээ үндэсний эв нэгдэл, Монгол цэргийн шилдэг уламжлалаа эрхэмлэн хүндэтгэж, цэргийн эрдэмд шамдан боловсорч, улсын нууцыг найдвартай хадгалж, Монгол Улсын хууль, цэргийн дүрмийг чанд сахин биелүүлэхээ батлан тангараглая

(Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд, 2022).

Эх орноо батлан хамгаалагч дайчин Би өргөсөн тангаргаасаа няцваас төрийн хууль ёсны цээрлэл хүлээнэ." гэж цэргийн тангараг өргөснөөр тус Их сургуулийн сонсогч болдог.

Гүн гүнзгий утга агуулга бүхий энэхүү тангаргийг сонсогчид үгчлэн цээжилдэг боловч мөн чанарыг нь төдийлөн ухаж ойлгохгүй байгаа нь дээрх зөрчлийн тоон мэдээллээс харагдаж байна. Тиймээс Монгол Улсын Цэргийн тангаргийн агуулгад буй гол ойлголтуудыг монгол хэлний үг зүйн хувьд болон ёс суртахууны зарчмын хүрээнд задлан шинжилж тайлбарлах нь сонсогчид тангаргаа ухамсарлан ойлгож түүнийг хэрэгжүүлэхэд тустай.

"Монгол Улсын иргэн Би Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ үнэнчээр биелүүлж" гэх хэсгийн *"Монгол Улсын иргэн"* гэдэг нь Монгол Улсын байнгын хүн амын тоонд багтах бөгөөд үндсэн хуулиар олгосон бүх эрхийг эдлэх эрхтэй, үндсэн хуульд заасан бүх үүргийг биелүүлэх үүрэгтэй Монгол Улсын уугуул оршин суугч бөгөөд "Иргэн" нь хүн ардын хүндэтгэлийн нэршил юм (Цэвэл, 2013). Энэ агуулга нь тангараг өргөж буй цэргийн алба хаагч бол Монголын ард түмний хүндэт төлөөлөл мөн гэсэн санааг

илэрхийлнэ. “...Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ үнэнчээр биелүүлж...” гэдэг нь хуулиар хүлээсэн эрх, үүргийн дагуу эх орон, нийгмийн өмнө хариуцлага хүлээж хуульд заагдсан үүргээ хэрэгжүүлэх нь хувь хүний ёс суртахууны гол үнэлэмж болохыг илэрхийлсэн байна. (Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд, 2022)

“...өвөг дээдсийнхээ ариун гал голомт болсон Монгол Улсынхаа халдашгүй дархан байдлыг амь бие үл хайрлан батлан хамгаалахаа...” гэх хэсэг бол “Монгол Улсынхаа дотоод, гадаад аюулгүй байдал, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах үүргээ ямар ч бэрхшээл, хүндрэлээс үл няцан хэрэгжүүлэх агуулгыг илэрхийлсэн бол “...эх орон, төр, ард түмэндээ андгайлан тангараглая...” гэх хэсэг нь эх болсон нутаг орон, ард олон, аав, ээж, хайртай дотно бүхнийхээ өмнө дээрх үүргийг биелүүлэхийн үнэн, шударга, бат нотыг амласан андгайлал бөгөөд энэ нь тангаргийн гол агуулгыг илэрхийлэл болж сонсогчдод ёс суртахууны эх оронч байх зарчмыг ухамсарлуулсан чухал хэсэг гэж үзэж болох юм.

Тангаргийн “...Би ард түмнийхээ үндэсний эв нэгдэл, Монгол цэргийн шилдэг уламжлалаа эрхэмлэн хүндэтгэж, цэргийн эрдэмд шамдан боловсорч, улсын нууцыг найдвартай хадгалж, Монгол Улсын хууль, цэргийн дүрмийг чанд сахин биелүүлэхээ батлан тангараглая...” (Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд, 2022) гэх хэсэг нь бүхэлдээ үндэсний бүхнийг дээдлэн хөгжүүлэхэд санаа, зорилго нэгтэй байж, Монгол цэргийн түүх бахархлыг залгамжлан хадгалах, тасралтгүй суралцах, хөгжүүлэх, хууль тогтоомжуудыг үргэлж даган хэрэгжүүлэхээ баталж нотолж буйг илэрхийлжээ. Энэ нь ёс суртахууны “хүнлэг энэрэнгүй байх”, “хамтач байх”, “хөдөлмөрч байх” зарчмуудыг

хэрэгжүүлэх агуулгатай шууд холбогдож байна.

“...Эх орноо батлан хамгаалагч дайчин Би өргөсөн тангаргаасаа няцваас төрийн хууль ёсны цээрлэл хүлээнэ.” (Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд, 2022) гэх төгсгөлийн хэсэг нь эх орныхоо төлөө үүрэг хариуцлага хүлээх баталгаа нотолгоо бүхий зорилгодоо хүрэхгүй эргэж буцах, ухрах, урваж шарваж (Цэвэл, 2013) хариуцсан үүргээ биелүүлэхгүй бол хуулийн дагуу цээрлэл буюу ял шийтгэл хүлээнэ гэдгээ илэрхийлсэн агуулгатай бөгөөд сонсогчийн төр, ард түмэндээ ам өчиг өгч буй андгайн хэсэг юм. Энэхүү ам өчиг, андгай нь цэргийн сонсогчдыг идэвхжүүлж, хариуцлагажуулж, зоригжуулж буй чухал хэсэг бөгөөд эх оронч бус үйлдэл, хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх агуулгатай юм. Энэ агуулга нь сонсогчдоос үнэч шударга байх, хэлсэн зорьсондоо хүрдэг байх зэрэг ёс суртахууны мэдрэмжүүдийг шаардаж байдгаараа ач холбогдолтой.

Монгол Улсын Цэргийн тангараг нь бүхэлдээ ёс суртахууны “Эх оронч байх”, “Хамтач байх”, “Хөдөлмөрч байх”, “Хүнлэг энэрэнгүй байх” зарчмуудын агуулгатай гэж үзэж болохоор байна.

Хоёр. Монгол Улсын Цэргийн дүрмүүдийн ёс суртахууны агуулга

Монгол Улсын Цэргийн дүрмийн Дотоод албаны дүрмийн хоёрдугаар бүлэгт цэргийн алба хаагчийн эрхэмлэх зүйл, нийтлэг эрх, үүргийг тодорхойлсон бөгөөд ёс суртахууны агуулга бүхий дараах заалтууд байна. Үүнд:

3 дугаар зүйл. Цэргийн алба хаагчийн эрхэмлэх зүйл 3.1. Эх оронч байх; 3.2. Эр зоригтой байх; 3.3. Шударга байх; 3.4. Ёс зүйтэй байх; 3.5. Тэсвэр тэвчээртэй байх, түүнчлэн “5.3.3.эрх бүхий албан тушаалтны баталсан ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх; 5.3.4.цэргийн цол, албан тушаалыг үл харгалзан





ᠬᠤᠠᠭᠠᠨ ᠰᠠᠬᠢᠭᠣᠯᠠᠭᠤᠨ
ᠬᠤᠠᠭᠠᠨ ᠰᠠᠬᠢᠭᠣᠯᠠᠭᠤᠨ

хүндэтгэлтэй, *ёс зүйтэй*, соёлтой харьцах”; “4.4.1. Монгол Улсын хууль тогтоомж, Цэргийн тангараг, Цэргийн нийтлэг дүрмүүдээр тогтоосон эрх зүйн болон *ёс зүйн хэм хэмжээ*, захирагчийн тушаалаар тогтоосон дэг журмыг цэргийн алба хаагч чанд сахин биелүүлэх нь Цэргийн сахилга мөн”, “4.2.Цэргийн сахилга нь хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэх, албаны хариуцлага, итгэл үнэмшил, *эх оронч үзэл, хүмүүжил, ёс зүйн хэм хэмжээнд тулгуурлах* ба дараах хэлбэрээр хэрэгжинэ”: “4.2.1.цэргийн алба хаагч нь эх орноо хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангахад бэлэн байх, захирагчид ухамсартайгаар захирагдах итгэл үнэмшлийг төлөвшүүлснээр”; “4.2.2.цэргийн алба хаагч нь Цэргийн нийтлэг дүрмүүд, *ёс зүйн хэм хэмжээний шаардлага* болон өөрийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагаа ухамсарласнаар”; “4.4.Цэргийн сахилга нь цэргийн алба хаагчаас дараах үүргийг биелүүлэхийг шаардана”: “4.4.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийг дээдлэн, өргөсөн тангарагтаа үнэнч байж, Цэргийн нийтлэг дүрмүүдийг чанд сахин биелүүлэх, цэргийн алба хаагчийн *ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх*”; “4.4.2. гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх”; “4.4.3.цэргийн албыг үнэнч шударгаар хааж, цэргийн эрдэмд шамдан суралцаж, өөрийн хариуцсан зэвсэглэл, техник, төрийн өмч хөрөнгийг хамгаалах”; “4.4.4.захирах, захирагдах зарчим, *ёслох, хүндлэх журмыг сахих, бусдад хүндэтгэлтэй хандах*”; “4.4.5.албан тушаалын үүргээ мадаггүй хэрэгжүүлэх”; “4.4.6.нийгмийн харилцаанд оролцохдоо цэргийн алба хаагчийн нэр хүндийг өндөрт өргөж, нийгмийн хэв журмыг үлгэр жишээчээр сахих” гэх мэт ёс суртахууны агуулгатай олон заалтууд байдаг нь сонсогчдод ёс суртахууны үүрэг болон тодорхойлогджээ.

Түүнээс гадна цэргийн алба хаагчдын *ёс суртахууны төлөвшилийг сайжруулах* чиглэлээр захирагч дарга нар цэргийн дүрмийн дагуу “9.1.6.бие бүрэлдэхүүний аюулгүй байдал, эрүүл мэнд, *ёс зүйн асуудлыг хариуцах*”; “10.2.8.бие бүрэлдэхүүнд эх оронч хүмүүжил төлөвшүүлэх, мэдээлэл сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг удирдан чиглүүлэх”; “12.1.9.цэргийн алба хаагчийн *ёс суртахуун, сэтгэл зүй*, бие бялдрын бэлтгэлжилтийг хангуулах”; “38.1.3.салааны бие бүрэлдэхүүний сахилга, хүмүүжил, сэтгэл зүйн байдлыг мэдэж, дэлгэрэнгүй судалгааг хөтлөх”, 8.20. Захирагч нь сахилгын шийтгэлийг үндэслэлгүй ногдуулах, цэргийн алба хаагчийн нэр хүндийг гутаах, *ёс зүйн зөрчил* гаргахгүй байх зэрэг үүргийг заасан байна.

Монгол Улсын цэргийн дүрмүүдийн дээрх заалтуудаар уг дүрмийг хэрэгжүүлэх ажиллагаа нь ёс суртахуунд суурилах бөгөөд захирагч дарга, багш нараас захирагдагсдын буюу сонсогчдынхоо ёс суртахууны төлөвшилд онцлон анхаарах үүргийг тодорхойлсноос гадна захирагч, багш нарын өөрсдийн ёс суртахууны мөн чанарыг чухалчилсан агуулгатай байна.

Өөрөөр хэлбэл Монгол Улсын Цэргийн дүрэмд ёс зүй, ёс суртахууны агуулга бүхий заалтууд бүхэлдээ ДХИС-ийн сонсогчдын алба үйл ажиллагааны амжилт нь ёс суртахууны хэм хэмжээ, ёс суртахууны үүргийг хэрхэн хэрэгжүүлэхээс хамааралтай болохыг илэрхийлсэн гэж үзэж болохоор байна.

Гурав. Дотоод хэргийн их сургуулийн сонсогчдын ёс зүйн дүрэм дэх ёс суртахууны гол агуулга

Их сургуулийн Суралцагчийн ёс зүйн дүрмийн дөрөвдүгээр зүйлд сонсогчийн ёс зүйн зарчмыг тодорхойлсон бөгөөд 4.1.1-д “хүнлэг энэрэнгүй байж, шударга ёсыг дээдлэн, хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна” гэж заасан. Энэ нь сонсогч бүр

хувь хүнийхээ хувьд болон төрийн алба хаагчийн хувьд ёс суртахууны хүнлэг энэрэнгүй байх, үнэнч шударга байх зарчмыг дээдэлж, төрийн алба хаагчийн хувьд явцуу ашиг сонирхолд автахгүй байхыг ёс суртахууны үүрэг болгожээ.

Мөн дүрмийн 4.1.2-т “хуулийг чанд сахиж, суралцах үйл ажиллагаандаа хариуцлагатай байна”, 4.1.3-т “их сургуулийн болон хувь хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэн хүндэтгэнэ” хэмээн заасан нь хууль, дүрэм, журмыг ягштал биелүүлж, үүрэг хариуцлагаа ухамсарлан, сургуулийнхаа нэр хүндийг ямагт өргөж явах, найз нөхдийнхөө болон багш, захирагч нарынхаа нэр алдар, эрхийг байнга хүндэтгэж явахыг чухалчилсан зарчим бөгөөд ёс суртахууны хүнлэг энэрэнгүй байх, хамтач байх зарчимтай уялдсан байна.

4.1.4-т “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байж, эрх тэгш, шударга байдлыг хангаж ажиллана”, 4.1.5-т “хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн төлөө хариуцлага хүлээнэ” гэсэн зарчмууд нь ардчиллын суурь зарчим болсон үзэл бодол, санал хүсэлтээ хэнээс ч хараат бусаар илэрхийлж болох, бүх сонсогч тэгш эрхтэй байх, мөн ёс суртахууны үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд тохирсон хариуцлага хүлээж сурах нь сонсогч хүний хувьд чухал чанар бөгөөд ёс суртахууны үнэнч шударга байх, хариуцлагаа ухамсарлах зарчимтай нийцэж байна.

Суралцагчийн ёс зүйн дүрмийн 4.1.6-т “ёс суртахууны үлгэр дуурайлтай суралцана” гэсэн зарчим нь сонсогч бүр хамт олныхоо дунд ёс суртахууны хувьд манлайлагч байхаас гадна, доод дамжааны сонсогчдын даган дуурайх, бахархал, хүндэтгэлийг хүлээсэн үлгэр жишээч сонсогч байх ёстой гэсэн агуулгыг илэрхийлсэн чухал зарчим болжээ.

Ёс зүйн дүрэмд заасан “5.1. Суралцагч нь суралцах үүргээ хэрэгжүүлэхдээ сургалтын хөтөлбөрийн агуулгыг хугацаанд нь бүрэн эзэмших, бие даан бүтээлчээр суралцах чадвар эзэмшинэ”, “5.2. Дамжааны захирагч-багш болон бусад багш, албан хаагч, ажилтнаас тавьсан шаардлага, өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх, багш, шавийн харилцааг хүндэтгэн дээдэлнэ”, “5.4. Хуулиар хамгаалагдсан төрийн болон албаны, хувь хүний нууцыг чандлан хадгална”, “5.5. Хамт суралцагчид болон багш нартайгаа аливаа асуудлаар харилцахдаа хичээл сургалтын ба сургалтын бус аливаа асуудалтай холбоотой бодитой шүүмжлэл, санааг хүлээн авч бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй хандан аливаа зөрчлийг эв зүйгээр шийднэ” зэрэг ёс суртахууны хэм хэмжээнүүд нь ёс суртахууны болон эрх зүйн үндсэн зарчмууд, цэргийн тангараг, цэргийн дүрмүүдийн ёс суртахууны агуулгатай нийцсэн бөгөөд мэдлэг ур чадвартай сонсогчдын, ирээдүйн төрийн алба хаагчдын ёс суртахууны төлөвшлийн суурь гэж үзэж болохоор байна.

Дөрөв. Ёс зүй, ёс суртахууны тухай

ДХИС-ийн сонсогч бүр өргөсөн тангараг, цэргийн дүрэм, ДХИС-ийн Ёс зүйн дүрэм дэх ёс суртахууны агуулгыг ойлгож мэдсэнээр тэдгээрийг албанд хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх юм.

Үндэсний аюулгүй байдлын оюун санааны дархлааны дотор ёс суртахууны төлөв байдал, үнэлэмж, сонголтын чиг хандлага онцгой байр эзэлдэг (Галиндэв, 2022, хууд. 91) гэсэн эрдэмтний үг ч бас учиртай.

Академич С.Нарангэрэл “Ирээдүйд улс орноо авч явах, цэргийн салбарт ажиллах хүүхдүүдийн эх орноо гэсэн сэтгэхүйг нь илүү бадрааж, зоригжуулж өгөх хэрэгтэй. Нөгөө талдаа хугацаат цэргийн алба хаагчид болоод офицер, ахлагчийг бэлтгэж байгаа сургалтын



МОНГОЛЫН ИРГЭДНИЙ ХАМГААЛАХ ЯАМ



ᠬᠤᠠᠭᠠᠨ ᠰᠠᠬᠢᠭᠠᠨ ᠰᠠᠭᠠᠨ

хөтөлбөрт цэргийн алба хаагчийн ёс зүйн сургалтыг заавал тусгах шаардлагатай. Гайхамшигт өвөг дээдсийнхээ баатарлаг түүхэн үйл явдлаас сэдэвлэж, ёс суртахуунлаг байхад бусдын хайр, итгэлийг үргэлж хүлээдгийг нь зааж сурга. Хэрэв ой ухаанд нь шингээж чадвал бие биеэ дэглэх, дорой нэгэндээ хүч хэрэглэх, ёс суртахуунгүй дур зоргоороо аашилж авирлах нь зогсоно” (Нарангэрэл, 2015) гэж бичсэн нь цэргийн алба хаагч, сонсогчдын ёс суртахууны мөн чанарыг онцолжээ.

“Ёс нь аливаа зүйлийн горим журам, “зүй” нь багц, цогц түүнчлэн зөв болно гэсэн утгыг илэрхийлдэг. Энэ хоёр үг хамтдаа “Хүн юу хийх, юунаас тагталзах ёстойг судалдаг шинжлэх ухааны нэр болно гэж ёс зүйн шинжлэх ухааны үндэслэгч Аристотель хэлсэн байдаг (Оюунчимэг, 2019, хууд. 64).

Хүн төрөлхтөн хоёр хуультай. Нэг нь хүн ёсыг илэрхийлэгч, хүн болохын хувьд зайлшгүй биелүүлэх шаардлагуудыг багтаасан хүн төрөлхтний үндсэн хууль болох “ёс суртахуун”, хоёр дахь нь эрх зүйн хэм хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хэрэгсэл болох “хууль” юм. Тийм учраас хүн бүр ялангуяа тангараг өргөсөн цэргийн алба хаагч бид бүхэн нийгмийн хуулийг хэрэгжүүлэн ажиллаж амьдрахын тулд хүн ёсны хууль болох ёс суртахууны зарчмуудыг баримталж байх нь зүйтэй.

Монгол хэлний тайлбар толиос харахад Ёс суртахуун гэдэг нь “дагавал зохих, хүнд байвал зохих зан суртал”, зан суртал нь “хэвшсэн ёс дүрэм, хэв журам” (Цэвэл, 2013) гэсэн утгыг тус тус илэрхийлж байна.

Ёс зүй нь ёс суртахууны тухай шинжлэх ухаан бөгөөд хувь хүний мөн чанарыг илэрхийлдэг ёс суртахууны зарчим, хэм хэмжээ, ёс суртахууны үүрэг, үнэлэмж, хувь хүний зан суртахууныг судалдаг.

Дүгнэлт

ДХИС-ийн сонсогчдын төр ард түмэндээ өргөдөг Монгол Улсын цэргийн тангаргийн зорилго агуулга нь ёс суртахууны үндсэн зарчим болох “Хүнлэг энэрэнгүй байх”, “Хамтач байх”, Хөдөлмөрч байх”, “Эх оронч байх” зарчмуудтай холбогдож байгааг бид бүхэн анзаарч албаа нэр төртэй хаах итгэл үнэмшил, хүсэл сонирхол, хариуцлагыг нэмэгдүүлэх ажлыг энэхүү тангаргийн мөн чанартай уялдуулан зохион байгуулах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл сонсогчдын өргөсөн амлалт, андгай бүхий энэхүү тангараг нь улс орны аюулгүй байдал ард түмний эрх ашигтай нягт холбоотой бөгөөд мэргэжлийн боловсон хүчин болсны дараа ч нийгмийн амьдралд байр сууриа эзлэхэд ёс суртахууны хувьд чухал сургууль болохыг ухамсарлуулах нь ач холбогдолтой.

Монгол Улсын цэргийн дүрэм дэх ёс зүйтэй холбоотой бүхий л заалтууд нь сонсогчийн алба, үйл ажиллагааны гол үндэс бол ёс суртахууны зарчим, мэдрэмжид тулгуурлах бөгөөд, тэдний хоорондын харилцаанаас эхлээд мэдлэг, үүрэг гүйцэтгэх чадвар, эх оронч байх үзэл хандлага бүгд ёс суртахуунд суурилах учиртайг харуулж байна.

Тиймээс бид бүхэн Монгол Улсын Цэргийн тангараг дахь ёс суртахууны агуулга, цэргийн дүрмүүдэд олон удаа давтагдсан ёс зүй, ёс суртахууны шаардлага бүхий үүргүүдийг хэрэгжүүлэхийн тулд ёс зүйтэй байх, ёс зүйн хэм хэмжээ, ёс зүйн хэм хэмжээний шаардлага, ёс зүйн зөрчил, ёс суртахуун, ёс суртахууны үнэлэмж зэрэг ойлголтуудын талаар зохих мэдлэгтэй байх шаардлагатай юм.

Ёс суртахууны хэм хэмжээ гэдэг нь хүмүүсийн зан байдлын тодорхой дүр загвар, хэвшиж тогтсон стандарт, хүмүүсийн зан байдлыг зохицуулагч шаардлагуудын цогц юм (Сумъяа, 2001, хууд. 55) гэсэн тодорхойлолт нь цэргийн

алба хаагч, сонсогчдын ёс суртахууны агуулгад тохирсон тодорхойлолт юм.

Санал

ДХИС-ийн сонсогчдод ёс суртахуун төлөвшүүлж, албаа нэр төртэй хаах итгэл үнэмшил, хүсэл сонирхол, хариуцлагыг нэмэгдүүлэх ажлыг Монгол Улсын Цэргийн тангараг, Цэргийн дүрмүүд, ДХИС-ийн Ёс зүйн дүрмээр тодорхойлсон ёс суртахууны хэм хэмжээний утга агуулгын түвшинд таниулах сурталчлах ажилтай уялдуулан зохион байгуулах нь зүйтэй.

Мөн ёс суртахууны төлөвшлөөр манлайлагч, хариуцлагатай, ур чадвартай, эх оронч, сонсогчийн загвар бий болгох боломжтой гэж үзэж байна.

Ашигласан материал

- Галиндэв, Б. (2022). *“Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдал: Хүн амын оюуны дархлааны асуудал” эмхтгэл*. Улаанбаатар.
- Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд (2022).
- Нарангэрэл, С. (2015). *“Ёс зүйг дээлэхүй”*. Улаанбаатар.
- Оюунчимэг, Б. (2019). *Ёс суртахууны тухай ном*. Улаанбаатар.
- Сумъяа, Б. (2001). *Ёс зүйн үндэс*. Улаанбаатар.
- Цэвэл, Я. (2013). *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар.



Дотоод Ажиргааны Яаман
МОНГОЛЫН Дотоод Ажиргааны Яаман